



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 106

Амардалай

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын А/10 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сумын хэмжээнд 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд "Сайжруулагч" хэмээх усан бар жилийн сар шинийн баярыг тохиолдуулан нийтийг хамарсан золголт, бүх төрлийн уралдаан тэмцээн, урлаг соёл, хурим найр, хүлээн авалтын арга хэмжээг хориглож хяналт тавьж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч (Л.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

Хоёр. Хурал цуглаан, сургалт семинарыг танхимын 50 хувийн дүүргэлттэйгээр, коронавирусын халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтын 3,4 дүгээр тунгийн хамралт, коронавирусын халдварын шинжилгээний хариуг харгалзан халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулахыг Соёлын төвийн дарга(Ш.Отгонцэцэг), Эрүүл мэндийн төвийн дарга(Т.Мөнхтуяа) нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний эрсдэл өндөр байгаатай холбогдуулан отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. "Сайжруулагч" хэмээх усан бар жилийн сар шинийн баярыг гэр бүлийн хүрээнд тэмдэглэж, коронавирусын халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалтад идэвхитэй хамрагдаж, халдвараас урьдчилан сэргийлэхийг нийт ард иргэдэд уриалсугай.

Тав.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Л.Золжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ

4880200474